

**Б.РИНЧЕНИЙ НЭР ТӨР СЭРГЭН МАНДАХАД Г.АКИМЫН
ӨГҮҮЛЛИЙН ОРУУЛСАН ХУВЬ НЭМРИЙН ТУХАЙД**

К.Окада

/Токиогийн Гадаад судлалын их сургууль/

Түлхүүр үгс: Бямбын Ринчен, Готовын Аким, “Эмтрээ нь үгүй эрдэнэ” өгүүлэл, нэр төрийн сэргэн мандалт, “Идүүлсэн бут ургадаг” баримтат кино

1

Монгол улсын Соёлын гавьяат зүтгэлтэн, Б.Ринчений нэрэмжит шагналтан, нэрт орчуулагч, доктор, профессор Хатагин овогт Готовын Аким (1942-) “Эмтрээ нь үгүй эрдэнэ” хэмээх өгүүллээ “Утга зохиол урлаг” сонины 1988 оны XII сарын 9-ний өдрийн 50 (1680) дугаарт¹ нийтлүүлсэн билээ. Тус өгүүлэл нь “Монголчууд алт, мөнгө, шүр, оюу, номин, сувд, тана, ган, зэсийг есөн эрдэнэ гэж эрхэмлэдэг билээ. ...Гэхдээ энд миний бие байгалийн ямар ч эрдэнээс илүү хайрлан дээдлүүштэй нэгэн хүн - эрдэнийн тухай өгүүлнэ. Тэр эрдэнийг Еншөөбү [Йөншөөбү] Бямбын Ринчен гэмой. Их эрдэмтэн, гарамгай уран зохиолч, суу билигт гүүш тэр хүн манай шинжлэх ухаан, урлаг утга зохиолд удах тусмаа улам өнгө орох нэгэн эрдэнэ байсан гэдэгт өөрчлөлт шинэчлэлтийн урин салхи сэвэлзэн байгаа өнөө үед эргэлзэх хүн ховор биз ээ” гэж эхлээд “Хүнд суртал, гүжир гүтгэлэгт хэчнээн балбуулавч эвдрээгүй, эвдрэх нь байтугай, эмтрээ ч үгүй РИНЧЕН - ЭРДЭНИЙН дууль”-ийг уянгалан дуулсан байдаг.

1988 оны XII сард хуралдсан МАХН-ын Төв Хорооны V бүгд хурлаас нийгмийн амьдралын бүх хүрээг хамарсан өөрчлөлт шинэчлэлт хийх шийдвэр гаргасан явдал хэдийгээр үйл явц нь алгуурлаж байсан² боловч, Г.Акимын тус өгүүлэл нийтлэгдэхэд таатай нөхцөл байдлыг бүрдүүлсэн нь дамжиггүй. 1988 оны X сард Төрийн шагналт яруу найрагч Шаравын Сүрэнжав (1938-)-ын “Долгионт жилүүдийн туужис” хэмээх “Эсэргүү” яруу найрагч Рэнчиний Чойном (1936-1979)-ын тухай дурдатгал³ нийтлэгдэж, Р.Чойномыг цагаатгах үйл явц эхэлсэн явдал ч Г.Акимын тус өгүүлэл нийтлэгдэхэд ямар нэгэн “түлхэц” өгсөн гэж үзэж болох юм.

2

Г.Аким тус өгүүллэйг “Японы тагнуул, эсэргүү, феодалын үеийг магтагч, жижиг хөрөнгөтний үзэлтэн, зөвлөлтийн эрдэмтдийг шүүмжлэн, Монгол

¹ Г.Аким, “Эмтрээ нь үгүй эрдэнэ”, *Утга зохиол урлаг*, 1988.XII.9, №50 (1680), II нүүрт.

² Монгол улсын ШУА-ийн Түүхийн хүрээлэн, *Монгол улсын түүх*, V боть (XX зуун), Редактор Ж.Болдбаатар, М.Санждорж, Б.Ширэндэв, “Admon” компани, Улаанбаатар, 2003, 405-р тал.

³ Ш.Сүрэнжав, “Долгионт жилүүдийн туужис”, *Утга зохиол урлаг*, 1988.X.28, №44.

Зөвлөлтийн найрамдлыг хялайн үзэгч, хуучны соёлыг дөвийлгөн, социалист монголын хөгжлийг үгүйсгэгч” гээд нам засгаас хатуу ширүүн зэмлэн буруушааж шүүмжилж байсан Б.Ринчений нэр төрийг сэргээн засах зорилготой туурвиж нийтлүүлсэн юм.

Г.Аким тус өгүүлэлдээ 1950-аад оноос 1970-аад он хүртэл Б.Ринченийг шүүмжилж, нэр төрийг нь гутааж ирсэн бүтээлүүдийг нэр заан тэмдэглэж, хариуд нь тодорхой баримтаар эрс шүүмжлэн няцаасан байна. Түүний гол гол бүтээлийн нэрийг дурдвал ийм буюу.

1. Ч.Чимид, “Манай утга зохиол дахь националист үзлийн тухай” өгүүлэл, *Үнэн*, 1950, №7.
2. Д.Сэнгээ, “Далан насад ч даруулга хэрэгтэй” шүлэг, *Үнэн*, 1953, №300.
3. “Доктор Ринченгийн сүүлийн үеийн зохиолууд дахь зарим харш үзэл санааны тухай” өгүүлэл, *Намын амьдрал*, 1959, №7.
4. “Бидний эгнээнд хөрөнгөтний үзэлтэнд байр байхгүй” өгүүлэл, *Үнэн*, 1959, №289.
5. С.Дашдэндэв, Ш.Нацагдорж, Т.Пагва, Ж.Пүрэв, Г.Чимэд нар, “Үндэсний явцуу үзлийн элдэв илрэлтэй эвлэршгүй тэмцье” өгүүлэл, *Үнэн*, 1959, №194.
6. С.Лочин, “Зохиолчийн үзэл санаа, хариуцлага” өгүүлэл, *Утга зохиол урлаг*, 1974, №32.
7. А.Лувсандэндэв, “Шүүмжлэлийн шүүмжлэл” өгүүлэл, *Үнэн*, 1975, №51.
8. “Эрдэмтэн хүний өндөр үүрэг” өгүүлэл, *Намын амьдрал*, 1976, №3.

Г.Аким дээрх өгүүлүүдийн дотор “Намын амьдрал” сэтгүүлийн 1976 оны 3 дугаарт нийтлэгдсэн “Эрдэмтэн хүний өндөр үүрэг” өгүүллийг “бичсэн эзэнгүй тэрхүү булай өгүүлэл” гэж дурдаад тодорхой баримтаар дэлгэрэнгүй шүүмжилсэн байна. Б.Ринчен болон түүний эцэг эх, төрөл садангийн түүх намтрыг гуйвуулан дайрч давшилсан тус өгүүллийг зарим хүн монгол хэл шинжлэлийн эрдэмтэн, академич А.Лувсандэндэв (1927-1997) бичсэн мэт ярьдаг. Үнэн худлаа бүү мэд. Харин Г.Акимын тус өгүүлэл нийтлэгдсэний дараа академич А.Лувсандэндэвийн ““Хэлмэгдсэн” болгон дүрсэлжээ”⁴, Москвагийн Нэхмэлийн дээд сургуулийн оюутан Г.Болд гэгчийн “Гэрэлтүүлэх гээд сүүдэртүүлжээ”⁵ зэрэг шүүмжлэлтэй хандсан хоёр эсэргүүцлийн өгүүлэл, өлгөц хэвлэгдэн гарчээ. Тэгэхэд Г.Аким хариуд нь “Эмтлэх гээд эвдэрснээ илчилжээ”⁶ гэдэг эсэргүүцлийн хариу өгүүллийг нийтлүүлж, дээрх хоёр өгүүлэл, өлгөцийг баримтаар эрс няцаасан нь буй.

3

Г.Аким дараа нь 1991 онд тус өгүүллийн агуулгыг улам баяжуулж, “Идүүлсэн бут ургадаг” хэмээсэн Б.Ринчений дурсгалд зориулсан баримтат киног туурвиж, Монгол Телевизийн уран бүтээлийн “Өлзий” нэгдлээс гаргасан.

⁴ А.Лувсандэндэв, ““Хэлмэгдсэн” болгон дүрсэлжээ”, *Үнэн*, 1989, №54.

А.Лувсандэндэв, ““Хэлмэгдсэн” болгон дүрсэлжээ”, *Монгол үндэсний утга зохиолын хэл бүрэлдэн тогтсон нь*, Эмхэтгэн редакторласан Л.Болд, “Онги Бээс” хэвлэлийн компани, Улаанбаатар, 2002, 443-449-р тал.

⁵ Г.Болд, “Гэрэлтүүлэх гээд сүүдэртүүлжээ”, *Үнэн*, 1989, №91.

⁶ Г.Аким, “Эмтлэх гээд эвдэрснээ илчилжээ”, *Утга зохиол урлаг*, 1989.V.19, №21.

Профессор Г.Акимын “Эмтрээ нь үгүй эрдэнэ” өгүүлэл бол Б.Ринчений нэр төр сэргэн мандахад чухал хувь нэмэр оруулж, “Идсэн эрүү хувхайрч, идүүлсэн бут ургадаг” гэсэн монгол ардын зүйр үг нь үнэн болохыг нотолсон байна.

Энэ дашрамд дурдахад, Г.Акимын “Эмтрээ нь үгүй эрдэнэ” өгүүллийг илтгэгч миний бие дэлгэрэнгүй зүүлт, тайлбарын хамт япон хэлээр орчуулж, “Bulletin of Japanese Association for Mongolian Studies” сэтгүүлийн 1989 (1990) оны 20 дугаарт⁷ нийтлүүлсэн болно.



⁷ゴトビーン・アキム（岡田和行訳）「砕けることなき宝石—ビヤムビーン・リンチェン」 [Gotovyn Akim (Kazuyuki Okada yaku), “Kudakeru koto naki hōseki: Byambyn Rinchen”] Готовын Аким (Орчуулсан Казүюки Окада), “Эмтрээ нь үгүй эрдэнэ: Бямбын Ринчен” 『日本モンゴル学会紀要』 [Nihon Mongoru Gakkai kiyō] Японы Монголч Эрдэмтний Нийгэмлэгийн мэдээ [Bulletin of Japanese Association for Mongolian Studies], №20, 1989 (1990), 68-86-р тал.

Тус орчуулгын тухай танилцуулга Г.Аким гуайн доорх веб сайтад бий.

<https://goakim.wordpress.com/2011/02/22/unbroken-jewel-byambyn-rinchen/#more-118>

Бас Б.Ринчений товч намтрыг Японд анх бичиж танилцуулсан бүтээл нь 二木博史「B.リンチェン」 [Hiroshi Futaki, “B.Rinchen”] Хироши Фүтаки, “Б.Ринчен” 『東洋文庫書報』 [Tōyō Bunko shohō] Дорно дахины номын сангийн мэдээ, №14, 1982, 89-91-р тал болно.



